цаашдын хөгжилд чухал үр нөлөө үзүүлэх юм.

Иймд дотоод болон гадаад орны ижил төстэй байгууллагуудад мөрдөгддөг эрхзүйн орчныг судалж, хэрэгжүүлэх боломжтой сонгон шалгаруулалтын арга зүйг Монгол Улсын Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад анх орох иргэдээс сонгон шалгаруулж авахтай холбогдсон эрхзүйн орчинд тусган оруулах шаардлагатай.

Ахлагчийн албан тушаалд анх орох иргэдийг журмын дагуу тодорхой хугацаанд "дадлагажих ажилтан”-аар томилж, дадлагажуулсны дараагаар ХСИС-ийн Ахлагчийн сургуульд мэргэжлийн анхан шатны сургалтад хамруулах гэсэн шат дараатай үйл ажиллагааны үндсэн дээр жинхлэн томилж ажиллуулах нь тухайн албан тушаалд хандах хандлага, байгууллагад тогтвор суурьшилтай ажиллах чин эрмэлзэл болон сэтгэлзүй, бие бялдрын чадавхыг тодотгон харуулах сайн талтай.

***Т.Мөнхдорж*** *- Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, онцгой байдлын хошууч*

## ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

***Хураангуй:*** *Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, эрх зүйн орчны өнөөгийн байдал, боловсронгуй болгох талаар өөрийн санал дүгнэлтээ гаргахыг зорилоо.*

***Түлхүүр үг:*** *Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, эрх зүйн орчин*

Дэлхий нийтээр гамшгийг онолын хувьд нийгмийн үйл явц гэж хүлээн авч, түүний улс орны тогтвортой хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгахын үндэс нь өртөж байгаа нийгмийн эмзэг хэсэгт анхаарлаа хандуулж тэдгээрт учирч болох эрсдэлийг бууруулах чиглэлд менежмент хийх хэрэгтэй гэсэн хандлага илүү давамгайлж байна. Үүнтэй холбоотойгоор гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа бүхэлдээ нийгмийн эмзэг хэсгийг чадавхжуулж учирч болох эрсдэлийг бууруулахад чиглэгдэх болсон.

Гамшгийн эрсдэлийг бууруулах нь маш нарийн зохицуулалт бүхий хөгжлийн хандлагатай олон талт асуудал бөгөөд түүнийг дан ганц гамшгаас хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын оролцоотой хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч бүх талын оролцоо, түншлэлийн замаар хэрэгжүүлэхийг чухалчилж байна.

Манай улсад сүүлийн 15 жилд тохиолдсон гамшгийн статистикаас харахад жилд дунджаар 2900 орчим аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 200 орчим хүн амь насаа алдаж, 100 орчим тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Нийт аюулт үзэгдэл, ослын 80 гаруй хувийг объектын гал түймэр харин үлдсэн 20 орчим хувийг бусад аюулт үзэгдэл, осол эзэлж байна. Иймд нийт гарч буй гамшиг, ослын дийлэнх нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санамсар болгоомжгүйгээс үүдсэн байгаа нь цаашид гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд бодлогын түвшинд олон ажил хийх шаардлага байгааг харуулж байна.

Иймд Монгол Улс болон бүс нутгийн хэмжээнд тохиолдож буй гамшгийн тоо, төрөл давтамж нэмэгдэж, учруулах хохирлын хэмжээ өсч байгаа нь гамшгаас хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх, эмзэг байдал, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах, санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, гамшгийн нөөцийг нэмэгдүүлэх шаардлагыг бий болж байна.

Улс орон, ард иргэдээ болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн зорилготойгоор Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр тогтоолоор Гал түймэртэй тэмцэх газар, Улсын иргэний хамгаалалтын газар, Улсын нөөцийн газруудыг нэгтгэж гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах. хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг зорилго бүхий Онцгой байдлын албыг байгуулсан.

‘Гамшгаас хамгаалах тухай" хуулийн зорилт нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон гамшгаас хамгаалах албаны тогтолцоо, зохион байгуулалт, удирдлага, үйл ажиллагаа, гамшгаас хамгаалах асуудлаар төрийн болон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эдлэх эрх, хүлээх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход гамшгаас хамгаалах алба, бусад байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд үйлчилнэ.

Тус хуулийн 4.1.1."гамшгаас хамгаалах” гэж гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, эдгээр үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх цогцолбор арга хэмжээг.

4.1.2, 'Гамшиг” гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа. дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох. мал. амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс. орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг, 4.1.5."гамшгийн эрсдэл" гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө. хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг, "урьдчилан сэргийлэх" гэж гамшгийн аюул, болзошгүй хохирлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хэмээн тус тус томъёолсон.

Мөн Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараахь үндсэн зарчмыг удирдлага болгосон[1]. Үүнд:

1. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг цаг хугацаанд нь явуулах;

2. гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ хүн ам, үйлдвэрлэлийн нягтрал, байршил, байгаль, цаг уурын нөхцөл, үйлдвэрлэл, технологийн онцлог, гамшгийн бодит аюулын хэр хэмжээг харгалзан үзэх;

3. гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээг иж бүрнээр хэрэгжүүлэх;

4. гамшгаас хамгаалах үйл ажиллагааг өмчийн төрөл, хэлбэрийг үл харгалзан зохион байгуулах;

5. төрийн болон төрийн бус байгууллага. иргэдийн хүч оролцоог уялдуулан зохицуулахаар зохицуулсан байдаг.

Гэвч Монгол оронд тохиолдох байгалийн аюулт үзэгдэл, технологийн болон үйлдвэрлэлийн осол, гамшгийн төрөл, тэдгээрийн давтамж, учруулж байгаа хохирлын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан "улс *орны гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах удирдлагын тогтолцоог нэгдмэл, үр нөлөөтэй, боловсронгуй болгох чиглэлээр эрх зүй, удирдлага зохион байгуулалтын ишнэчлэлийг эрх зүйн хүрээнд хийх"* шаардлага зүй ёсоор гарах болсон.

Нөгөө талаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой хуулиудыг гамшгаас хамгаалах олон улсын жишиг, хандлагад ойртуулахад хуулийн шинэчлэлийн гол агуулга чиглэсэн.

[1] Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017

Түүнчлэн ‘Гамшгаас хамгаалах тухай" хуульд 2005, 2007, 2011,2012 онуудад нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхой хуульчлаагүйгээс төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжид энэ ажил орхигдоход хүрч байгаа нь практик амьдралаас харагдсан тул болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог тодорхой болгон хуульчлах шаардлагатай болсон тул 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр ‘Гамшгаас хамгаалах тухай" хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Хуулийн шинэчилсэн найруулга нь гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, гамшгийн хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, сэргээн босгох ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, зохицуулахтай холбогдон үүсэх харилцааг тодорхой зохицуулсан.

Мөн гамшгийн эрсдэлийг бууруулах удирдлага зохион байгуулалтын талаар зарчмын шинжтэй дараах асуудлыг тусгасан. Үүнд:

1. “гамшиг”, “осол” зэрэг нэр томьёоны тодорхойлолтыг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн томьёолох, “гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаа”, “гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх ажиллагаа’", "эрэн хайх, аврах ажиллагаа”, “гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаа”, “сэргээн босгох ажиллагаа” зэрэг гамшгаас хамгаалах чиг үүрэг болон олон улсын хүмүүнлэгийн тусламжтай холбоотой нэр томьёоны тодорхойлолтыг нэмж томьёолсон.

2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үндсэн чиглэл нь гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаа байх бөгөөд гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагааны хүрээнд[1]:

- гамшгийн эрсдэлийг үнэлэх;
- гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх;
- гамшгийн эрсдэлийг бууруулах;
- гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах;
- гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх;
- гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах;
- гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх.

[1] Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017он

3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж. аж ахуйн нэгж, байгууллага харьяалал, өмчийн төрөл. хэлбэрээс үл хамааран гамшгийн эрсдэлээ тодорхойлж. гамшгийн эрсдэлийн үнэлгээг зохих тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр хийлгэдэг байхаар тусгасан.

4. Засаг захиргаа. нутаг дэвсгэрийн нэгж, аж ахуйн нэгж, байгууллага харьяалал. өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран гамшгаас хамгаалах үйл ажиллагаагаа төлөвлөсөн байх.

5. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон гамшгаас хамгаалах албад, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийн ялгааг нарийвчлан зааж өгсөн.

6. Гамшгийн хор уршиг, хохирлын үнэлгээ хийхтэй холбоотой асуудлыг шинээр оруулж, аврах ажиллагааны зарим бүрэлдэхүүн хэсгийг тодотгосон.

7. Гамшгийн дараах сэргээн босгох ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг тусгах. Сэргээн босгох ажиллагаа нь нийгмийн бүтэц, үйлчилгээг сэргээн босгох, дэд бүтцийг сэргээн босгох гэсэн чиглэлтэй байх ба сэргээн босгох урт хугацааны арга хэмжээ нь улс, орон нутгийн хөгжлийн бодлого, зорилтод нийцсэн байхаар тусгасан.

8. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс үзүүлэх тусламж, дэмжлэг, түүнчлэн олон улсын хүмүүнлэгийн тусламжтай холбогдсон зохицуулалтыг тусгасан.

9. Гамшгаас хамгаалах чиглэлээр үндэсний аюулгүй байдлыг хангах, гадаад харилцаа, түншлэл, хамтын ажиллагааг улсын хэмжээнд бодлого, зохицуулалтаар хангах, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Гамшгаас хамгаалах үндэсний зөвлөлийг, аймаг, нийслэл, дүүрэгт гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалтыг хариуцах чиг үүрэг бүхий гамшгаас хамгаалах орон нутгийн зөвлөлийг байгуулсан.

10. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тэдгээрийн хүн ам, эдийн засаг, нийгэм, газарзүйн онцлог зэргээс хамааруулж гамшгаас хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны ажилтантай байх зэргээр гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтыг нарийвчлан хуульчилж өгсөн.

Ингэснээр гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчин боловсронгуй болж, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах таатай нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн гамшгаас хамгаалах /гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох цогц арга хэмжээ/, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдэж, түүнийг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн дараах эерэг үр дагавар гарна:

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохицуулалтын механизм боловсронгуй болж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо нэмэгдэнэ.
2. Гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх ажиллагаа эрчимжиж, гамшгийн эрсдэл буурна.
3. Гамшгийн үеийн хүмүүнлэгийн тусламж, түүнийг зохицуулахтай холбогдон үүсэх харилцаанд тулгамдаж байгаа доголдолтой тал арилна.

Хөгжлийн үйл явц бүх түвшинд бүх салбарыг хамарч хийгддэг учир гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг ч мөн адил бүх түвшин. бүх салбарт уялдуулан тусгах хэрэгтэй. Бүх шатны засаг захиргааны байгууллагууд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хөгжлийн үйл ажиллагаандаа тусгах үйл явцаа зохицуулалт, уялдаа холбоотойгоор хийх хэрэгтэй.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа нь олон салбарыг хамарч хэрэгждэг тул хэвтээ буюу салбар хоорондын зохицуулалт хийх нь чухал. Гамшиг нь газар ашиглалтын төлөвлөлт, байгаль орчны доройтол, аюулгүй байдал хангаагүй дэд бүтэц, нийгмийн халамжийн муу систем. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хязгаарлагдмал байх, бэлэн байдлын хангалт муу байх зэрэг асуудалтай нягт уялдаа холбоотой. Эдгээр асуудлыг яам, агентлагууд хариуцан хэрэгжүүлдэг тул эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үндэсний зөвлөлийг хуулинд тусгаж өгсөн.

Хувийн хэвшил хөгжлийн түвшинд хөгжлийн үйл явцад чухал үүрэгтэй оролцдог тул гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлыг тэдгээр байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах нь чухал ач холбогдолтой байдаг. Өөрөөр хэлбэл хэвтээ болон босоо зохицуулалтын механизмууд нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хөгжлийн үйл явцад уялдуулан тусгах таатай орчинг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Аливаа улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшил, ололт амжилт нь хүний болон хүний оролцоогүйгээр үүсэж болох аюул занал доор

үргэлж байсаар байдаг. Эдгээр аюул заналын тод жишээ бол байгалийн аюулт үзэгдэл, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшиг юм.

Монгол оронд тохиолдож байгаа гамшгийн төрөл, тэдгээрийн давтамж. учруулж буй хохирлын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа өнөө үед гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн нөөцийг тогтоосон тоо хэмжээнд бүрдүүлэх хөрөнгийг улсын төсөвт үе шаттай тусгах асуудалд түлхүү анхаарах. гамшгаас хамгаалах тогтолцоог шинэчлэх, гамшгаас хамгаалах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлага бий болж байна. Иймд дараах зохион байгуулалтын ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажиллах журмыг баталж, эрх зүйн орчинг бий болгох, бүтцийг бий болгож улс. орон нутгийн төсөвт гамшгаас урьдчилан сэргийлэх гамшгийн эрсдэлийг бууруулахад шаардагдах төсвийг баталдаг тогтолцоог бий болгох;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд УИХ, Засгийн газар, яам хоорондын болон орон нутгийн харилцан ажиллагаа чухал байр суурь эзлэх бөгөөд ‘Гамшгийн эрсдэлийг бууруулах, санхүүгийн чадавхыгбэхжүүлэх ажлын удирдлага, зохион байгуулалтын бодлого, хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх иж бүрэн урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар /УИХ, Засгийн газар/ батлуулж хэрэгжүүлэх. Салбар, яамдын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, эрсдэлийг удирдах бүтцийг бий болгох.
- Гамшгийн эрсдэл хуваалцах давхар даатгал, даатгалын тухай хууль боловсруулж батлуулах, түүнчлэн гамшгийн үеийн бичил зээл тусламжийг зохицуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох.
- Хүн ам, мал амьтан, байгаль орчинг гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд улс, орон нутаг, хувийн хэвшлээс оруулж байгаа хөрөнгө оруулалт нь гамшгийн эрсдэлийг бууруулах хамгийн үр дүнтэй арга мөн тул нийгэм-эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлж, төр болон хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх замаар хэрэгжүүлэх.
- Улсын их хурлын 2016 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийг үе шаттай хэрэгжүүлж, уур

амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх.

• Төрийн болон төрийн бус байгууллага иргэдэд зориулсан байгалийн аюул, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлаар мэдээлэл. мэдээг нэгтгэж, дүн шинжилгээ хийх, түгээх үйл ажиллагааг нэгдсэн тогтолцоонд оруулах мэдээллийн сан байгуулах ажлыг зохион байгуулах, түүнд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт суулгах.

• Засгийн газрын болон орон нутгийн гамшгийн нөөц хөрөнгийн хэмжээг тухайн төсөвтэй нь уялдуулан жил болгон тодорхой сан бүрдүүлдэг байх.

• Үндэсний эрсдэлийн сантай болох, хууль эрх зүйн үндсийг бий болгох /Засгийн газрын хуримтлалын сан/

***Л.Билэгдэмбэрэл*** *— Хууль сахиулахын удирдлагын академийн*
*821 дүгээр дамжааны суралцагч, онцгой байдлын ахмад*

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

***Хураангуй.*** *Энэхүү илтгэлээр худалдан авах ажиллагааны өнөөгийн удирдлага, зохион байгуулалтыг хууль эрх зүйн орчинд хэрхэн заасан талаар талаар авч үзэхийг зорилоо.*

***Түлхүүр*** *үг. Худалдан авах ажиллагаа.*

Манай орон зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжээд 20 гаруй жил болж байна. 2000 онд анх батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай хуулийн шинэчлэн найруулсан төслийг 2005 онд УИХ-аар хэлэлцэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баталсан цагаас хойш худалдан авах ажиллагааны орчин бүхий л салбарыг бүрэн хамарч шударга, нээлттэй сонголтыг хийх боломжийг бий болгосон.

Засгийн газар нь батлан хамгаалах, боловсрол, нийгмийн аж байдал, байгалийн нөөцийг эзэмших, эрүүл мэнд, эмнэлэг, зам тээвэр, цагдаа түүнчлэн шуудангийн үйлчилгээ, сансар судлал, хот тохижуулах зэрэг улс олон нийтийн зориулалттай үйл ажиллагааг явуулдаг байгууллагыг багтаадаг томоохон зах зээл бөгөөд дараах онцлогуудыг агуулж байдаг.

> Хувийн хэвшлийнхний хувьд эрхэлж явуулахад хэтэрхий өндөр зардалтай, ашиг олох нь тодорхойгүй, эрсдэлтэй

> Тухайн улс ард түмний нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах.